

3. Мөн тэнд .х.223-р тал.
4. С.Д.Дылыков Өвөр Монголын ардчилсан хөдөлгөөн. УБ, 1957.х. 18-19-р тал.
5. “Хятад дахь монголчууд” УБ, 1996 .х. 34-р тал.
6. Л.Жамсран “Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал. УБ. 1996 .х. 17-р тал.
7. “БНХАУ-ын ӨМӨЗО” УБ, 1981 .х. 35-р тал.
8. “Дунбэй жибао” сонин 1946 11.10
9. “БНХАУ-ын ӨМӨЗО” УБ, 1981.х. 64-р тал.
10. “ӨМӨЗО-ы Их толь” 1994 он Хөх хот .Х. 49-р тал.
11. “Солонго” сэтгүүл 1995 №7 8-р тал.

Шүүмж Б.Лхамсүрэн. “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” зохиолын тухай.

В.В.Грайворонский С.Г.Лузянин

1980-аад оны сүүлч-90-ээд оны эхнээс, нэн ялангуяа 1990 оны ардчилсан тайван хувьсгал ялсанаас хойш Монголын нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарсан радикал өөрчлөлтүүдийн явцад, XX зууны эхнээс авахуулаад Монголын шинэхэн түүхийг бүхэлд нь нэхэн ойлгох нарийн төвөгтэй, зөрчилтэй ажил үйлс чухал суурь эзлэв. Сүүлийн жилүүдэд монголын түүхчид, нийгэм судлаачид хуучирсан олон баримтлалыг хянан үзэх, түүхэн үйл явдлуудыг бодитой бөгөөд тал бүрээс нь тусган харуулах, хилс хэрэгт хэлмэгдсэн буюу мартагдсан зүтгэлтний ролийг үнэлэх талаар ихээхэн ажил хийжээ.

Энэ талаар гүйцэтгэсэн ажлын дотор Монголын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгээс эрхэлсэн “XX зууны Монгол” хэмээх эрдэм шинжилгээний том төсөл чухал байр эзлэнэ. Бидний шүүмж бичиж буй монголын эрдэмтэн ШУА-ийн гишүүн Б.Лхамсүрэнгийн бүтээл нь уул номын редактор М.Санждоржийн өмнөх үгэнд хэлсэнчилэн дээрхи төслийн эхний хэсэг бөгөөд гол төлөв монгол талын баримт сэлтийг үндэс болгосон байна.

Нэг сэдэвт зохиол нь хэмжээгээр харьцангуй том биш боловч, XIX зууны эцсээс өнөө үеийг хүртлэх маш урт хугацаа буюу бараг 100 жилийг хамарч монголын ард түмний төр улсаа сэргээхийн төлөө, тэмцлийн түүхийг 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтаас аваад 1994 онд баталсан

өнөөгийн Монголын гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн зүйлийг хүртэл улируулан авч үзсэн байна.

Зохиол нь таван бүлэг, ном зүйгээс бүрджээ. Номын бүтэц, гол агуулгыг бүлгүүдийн гарчиг тусгаж байгаа учир Тэдгээрийг дурдвал:

1. Монголын үндсээ чөлөөлөх хувьсгал, үр дүн. Монголын тусгаар тогтнол хязгаарлагдаж устгагдсан нь. 2. Ардын хувьсгал-Монголын тусгаар тогтнолын шинэ сурвалж. Ардын засгийн гадаад бодлого. Улс гүрнүүдийн хандлага. 3. Дайны аюул өсч дэлхийг хамарсан үе дэх БНМАУ-ын гадаад харилцаа. 4. БНМАУ олон улсын харилцааны тавцан дээр гарахын төлөө тэмцсэн нь. 5. Социалист системийн ба түүний задралын үе дэх Монголын гадаад улс төрийн харилцаа эдгээр болно. Үүнээс үзвэл, донсолгоонт ХХ зууны нөхцөлд үндэсний тусгаар тогтнол, төр улсынхаа төлөө монголын ард түмний тэцлийн зангилаа бүх үеийг шинэ байр суурьнаас тодорхойлох гэсэн анхны оролдлогын нэг мөн байна.

Судалгаа нь эх сурвалжийн найдвартай баазад түшиглэснийг тэмдэглэе. Зохиолд Монголын түүхийн төв архив, Монголын гадаад харилцааны төв архив, МАХН-ын төв архив, Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэл сан зэрэг гол төлөв Монголын төв архивуудад хадгалагдаж байгаа баримт материалыг ашиглаж заримыг эрдэм шинжилгээний эргэлтэнд шинээр оруулсны жишээг дурдвал: ХХ зууны эхэн үеийн оросын нэрт монголч эрдэмтэн В.Котвич, Монгол дахь Зөвлөлт Орос улсын анхны бүрэн эрхт төлөөлөгч В.И.Юдиний хувийн архив, 1925-1927 онд ЗСБНХУ-аас БНМАУ-д сууж байсан бүрэн эрхэт төлөөлөгч П.М.Никифоровын өдрийн тэмдэглэл, Монголын шашны нэрт зүтгэлтэн Дилав хутагт Жамсранжавын дуртгалын материалууд болно.

Зохиогч мэдээж болон бага мэдэгдэж байсан баримтуудыг авч үзэхдээ марксист-ленинист үзэл суртлын дангаар ноёрхлын нөхцөлд тогтсон хэд хэдэн хуучирсан үнэлэлт, ойлголоос татгалзаж, улс төрийн байдлын урсгал, сэтгэл хөөрөлд үл автагдан бодитойгоор задлан шинжилэхийг эрмэлзсэн нь бүтээлийн ололт эргэлзээгүй мөн гэж бид үзэж байна. Үүний хамт Б.Лхамсүрэн, нам улсын хуучин удирдлагын арга барилыг шүүмжлэгчид болон өөрөөр сэтгэгчдийг дарахын тул урьд цөөнгүй хэрэглэгддэг байсан үндсэрхэх явцуу үзэл хэмээх зэмлэлээс зайлсхийж аливаа нарийн ээдрээтэй байдлыг шинжлэхдээ юуны өмнө

монголчуудын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэх үзлийг тууштай баримталжээ.

Монголын шинэхэн үеийн түүхийн нэн чухал нэг асуудал бол манжийн захиргааг хөөн зайлуулж Хятадаас Монгол тусгаарласныг зарлан бүддийн шашны тэргүүн богд Жавзандамба гэгээнийг хаан ширээнд өргөмжилж шинэ он тооллыг тогтоосон XX зууны эхний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг зохих ёсоор үнэлэх явдал билээ. Зөвлөлтийн монгол судлал болон монголын түүхийн шинжлэх ухаанд дээр дурдсан үйл явдлыг монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялсан төдий явдал гэж үзэх албан ёсны үзэл саяхан болтол давамгайлж байлаа. Харин суулийн жилүүдэд монголын түүхчдийн дунд Монголд 1911 онд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж Монголын үндэсний тусгаар тогтнолыг тунхаглан Монголын үндэсний төр улсыг сэргээсэн гэдэг үзэл өргөн дэлгэр болов.

Шүүмж бичиж байгаа бүтээлийг зохиогч энэхүү үзлийг бүрэн хуваалцаж “Монгол улс 220 жилийн дараа үндэсний тусгаар тогтнол, төр улсаа сэргээн тогтоосон нь тэр үед бүрэлдэн бий болоод байсан олон улсын харилцааны тодорхой нөхцөл байдлыг ухаалгаар мэдрэн ашиглаж, зоримог шийдэмгий тэмцсэн монгол түмний тэмцлийн үр дүн байв. Монголын үндсээ чөлөөлөх хувьсгал ялж Манж чин улсаас хэрэг дээрээ салж тусгаар улс байгуулснаас хойно буюу 1912 оны 2-р сард чин улсын эзэн хаан ширээнээс бууж Хятадад Дундад иргэн улс байгуулсныг зарласан” /№10-11-р тал/ гэж дүгнэжээ. 1911 онд Чин улсаас Монгол тусгаарласнаа тунхагласан нь XX зууны монголын түүхийн гарамгай үйл явдал, монголын ард түмний олон жилийн үндэсний эрх чөлөөний тэмцлийн болон богд гэгээн тэргүүтэй монголын эрх баригч дээдэс орос, Хятадын хооронд чадамгай маневралж Хятадад Синхайн хувьсгал ялсны дүнд бий болсон зохистой нөхцөл байдлыг ашигласны үр дүн мөн гэдэг дээр зохиогчтой санал нийлэхгүй байх аргагүй. 1915 онд Орос, Монгол, Хятадын хооронд байгуулсан Хиагтын хэлэлцээрийн үр дүнг үнэлэх талаархи монголын түүхчдийн дотор маргаантай байдаг нарийн төвөгтэй асуудал дээр Б.Лхамсүрэнгийн эзэлсэн байр суурь нэлээд сонирхолтой. Хиагтын хэлэлцээрийн дүнд Монгол нь Орос, Хятадын даралт доор суверенитетээ хязгаарлаж өргөн автономит Хятадын сюзеренитетийг хүлээсэн билээ. Б.Лхамсүрэн “Хиагтын гэрээ нь

империализмын колонийн тогтолцоо ид ноёрхож байсан нөхцөлд их бага, хүчирхэг буурай улсуудын хооронд байгуулсан эрх тэгш биш гэрээний нэг” /22-р тал/ гэж үзэхийн хамт энэ гэрээнд оролцогчдын тухайн үеийн сонирхол тусгагдсаныг харгалзан үзүүштэй гэжээ. Жишээ нь “Дундад иргэн улс Монголын тусгаар байдлыг бүрмөсөн устгаж чадаагүй боловч Өвөрмонголын зэрэг дотоод чуулган хошуудыг бүрэлдэхүүндээ үлдээж Гадаад Монголыг ёс төдий ч гэсэн эзэрхэх эрхийг олж авснаар өөрийн орны олон нийт ба гадаад ертөнцийн өмнө Дайчин улсын залгамжлагч гэж харагдах болов. /22-23-р тал/ гэжээ. “Хаант Орос улсын хувьд гэвэл нэгэнт эхэлсэн дэлхийн нэгдүгээр дайны нөхцөлд гол анхаарлаа Европод хандуулж байсан болохоор Алс дорнодын улс хоорондын харилцааг хурцатгахыг үл хичээж байсны зэрэгцээгээр Гадаад Монголыг Хятадын хэмжээт эзэрхэлд байлгах нь тэнд олж авсан улс төр, эдийн засгийн давуу байдлааа бусад их гүрний өнгөлзөлгөөс сэргийлэн хадгалах сонирхолд нь нийцэж байжээ.”/23-р тал/ гэж зохиогчийн үзсэнийг бид зөв гэж бодож байна.

Б.Лхамсүрэн “Хиагтын гэрээгээр Монголын дахин сэргэсэн тусгаар тогтнол эвдэгдсэн” /мөн тэнд/ гэж цохон тэмдэглээд монголчуудын хувьд маргашгүй чухал энэ баримтыг монголын олонхи түүхчдийнх шиг давтан тэмдэглэхээр хязгаарлагдсангүй, Хиагтын хэлэлцээрийн үр дүнг нэлээд гүнзгий цэгнэж “Монгол нь дотооддоо нэлээд өргөн хэмжээний автономит эрх эдлэж хөрш хоёр гүрний хөндлөнгөөс оролцохыг хязгаарлан бас улс төрийн бус асуудлаар гадаад олон улс гүрэнтэй харилцах боломжтой болсон юм гэжээ. “Монголын тал Хиагтын гэрээгээр тогтоосон зүйлсийг тусгаар тогтнолоо бэхжүүлэх нэг алхам гэж үзэж байсан бол Хятадын зүгээс түүгээр түрий барин Монголыг өөрийн бүрэн эрхэнд оруулах далд санаа агуулж байв” /мөн тэнд /. Хиагтын хэлэлцээрийн зөрчилтэй, бат бэх биш нь дараагийн жилүүдийн үйл явдлаар нотлогдсон гэж зохиогч зөв зүйтэй хэлжээ. 1919 оны сүүлчээр Хятадын засгийн эрх баригчид Монголд цэргээ оруулж монголын зарим зүтгэлтний дэмжлэгтэйгээр Хиагтын хэлэлцээрийг цуцалсан билээ.

Автономийн үеийн /1915-1919/ Орос, Монголын хоорондын харилцааны тухай гэвэл онцын өөрчлөлт гараагүй гэж зохиогч үзжээ. “Оросын хаант засаг, түүнийг 1917 оны 2-р сард халсан Түр засаг, мөн оны 10-р сард байгуулагдсан Зөвлөлт засаг, Сибирьт тогтож байсан Колчакийн засгийн аль

алин нь дэлхийн дайн ба иргэний дайнд гүнээ автсаны улмаас Монголын талаар идэвхтэй бодлого явуулах боломжгүй байжээ. Мөн түүнчлэн автономит Монолын засгийн газар умард хөрштэй харилцахдаа болгоомжлох байр суурьтай байв. /26-27-р тал/. Автономит засгийн газар нь 1918 оны 3-р сард Зөвлөлт засгийн Ардын комиссараас албан ёсоор анхааруулсныг үл харгалзан оросын хуучин консултай харилцсаар байв. 1919 оны 8-р сарын 3-нд Зөвлөлт Орос улсын засгийн газрын Гадаад хэргийн комиссараас автономит Монголын засгийн газар ба ард түмэнд Зөвлөлт Оросын улс урьдын эрх тэгш бус бүх гэрээнээс татгалзаж хоёр орны хооронд шинэ харилцаа тогтоох үндсэн зарчмуудыг тодорхойлон нэн даруй хэлэлцээ хийж дипломат харилцаа тогтоохыг санал болгосон тусгай илгээлтийг ч Богд гэгээний засгийн газар хайхарч үзээгүй юм. Монголын засгийн газрын ийм байр суурийг зохиогч нэгдүгээрт, 1919 оны 8-р сард Гадаад Монгол тусгаар тогтнох байтугай автономит эрхээ цуцлуулахын даваан дээр очоод байсан, хоёрдугаарт, монголын эрх баригчид” улааны аюулаас ихэд сэрэмжилж байснаар тайлбарлажээ.

Өнгөрсөн жилүүдэд Б. Лхамсүрэн нам засгийн удирдлагад МАХН-ын Төв Хорооны үзэл суртлын ажил эрхэлсэн нарийн бичгийн дарга, Улс Төрийн Товчооны орлогч гүшүүн зэрэг өндөр албан тушаалд байж тус орны гадаад улс төрийн шугамыг онолын талаар үндэслэх, хэрэгжүүлэн биелүүлэх, зөвлөлт-моноголын бүх талын хамтын ажиллагаа, хоёр орны найрамдлыг хөгжүүлэн бэхжүүлэхэд идэвхтэй оролцож байсан билээ. Социалист систем ба ЗСБНХУ задарсны дараа, Монголын амьдралд ардчилсан эрс өөрчлөлт гаргах явцад зохиогч урьдынхаа үзэл, дүгнэлтийн олонхийг, тухайлбал үндэсний ба интернационал зүйлийн хоорондох, дотоод гадаад хүчин зүйлийн хоорондох харьцааны тухай, социализмын мөн чанар, байр суурь, роль үүргийн тухай, октябрийн хувьсгалын нөлөөний тухай асуудлаар доривтой хянан үзсэнийг түүний бүтээл гэрчилж байна. Жишээлбэл, Б.Лхамсүрэн урьдын зохиолууддаа Монголын Октябрийн хувьсгалын үзүүлсэн нөлөөг онцгой их ач холбогдолтой гэж үздэг байсан бол бидний шүүмж бичиж байгаа зохиолдоо Орос оронд гарсан 1917 оны хөрөнгөтний ардчилсан болон пролетарийн хувьсгал монголын олон нийтэд үлэмж нөлөө үзүүлсэн гэж үзэхээр хязгаарлагдаж үүний хамгийн тод илрэл

нь нийслэл Хүрээнд монголын хувьсгалчдын нууц хоёр бүлгэм үүссэн явдал гэж дурджээ /27-р тал/.

Монгол Ард улс ба Зөвлөлт Орос улс, БНМАУ ба ЗСБНХУ-ын хоорондын харилцааны шинж чанарыг үнэлэх зохиолчийн өнөөгийн хандлага нь Зөвлөлтийн монгол судлал ба БНМАУ-ын нийгмийн ухаанд уламжлан тогтсон дан ганц зөргөөр үнэлэх, үзэл сурталчилсан хуучин үнэлэлтээс татгалзаж, туйлшрах, үгүйсгэх, өрөөсгөл, хөнгөн хийсвэр дүгнэлтээс зайлсхийн, саяханы түүхэнд бодитой, шинжлэх ухаанчаар хандсанаар тодорхойлогдож байна. Нэг бүлэгт зохиолын гол ололтын нэг нь үүнд оршино гэж бид үзэж байна.

Зохиогч Монголын статусыг тодорхойлох, Зөвлөлт Орос улс, улмаар ЗСБНХУ ба Хятад улсын байр суурийн өөрчлөлттэй холбогдсон үйл явцыг албан баримт бичгүүдээс авсан олон ишлэлд түшиглэж улируулан үзжээ. Тухайлбал Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх талаар Зөвлөлт Орос улс ЗСБНХУ-ын байр суурь тууштай биш байсан, энэ нь 1924 оны 5-р сарын 31-нд ЗХУ-аас Хятад улстай харилцах асуудлуудыг зохицуулах үндсэн зарчмуудын тухай байгуулсан хэлэлцээрт тусгагдсаныг харуулжээ. “1924 оны зөвлөлт-Хятадын хэлэлцээрээр Монголыг Хятадын суверенитетэд орших бүрэлдэхүүн хэсэг гэсэн нь Монголын хүсэл зоргийг үл хайхарсан төдийгүй, 1919 оны зөвлөлт засгийн тунхаглал, 1921 оны Монгол-Зөвлөлтийн гэрээний заалтад харшилсан зүйл байлаа. Энэ нь Хятадаар өөрийгөө зөвшөөрүүлж харилцаагаа зохицуулахын тулд Зөвлөлт улсын арга буюу хийсэн буулт гэж тухайн үед ойлгогдож байсан боловч жинхэнэ санаа бодлого нь нэлээд гүнзгий байсныг цаашдын үйл явдал нотолсон” /48-р тал/ гэж Б.Лхамсүрэн үзжээ.

Цаашлаад, зохиогч “Зөвлөлт улс ба түүний коммунист намын удирдлага, бага буурай үндэстэн, түүний дотор Монголын өөртөө засах эрхийг тунхаглаж байсан боловч хаант Оросын үеийн эзэгнэгч бодлогоос салж чадаагүй байжээ.” /мөн тэнд/ гэсэн зарчмын ерөнхий дүгнэлт хийсэн байна.

Өөрөөр хэлбэл, Б.Лхамсүрэн урьдах үзлээ үндсээр нь хянан үзэж Монголын хувьд хаант Орос улс, Зөвлөлт Орос улс ба ЗСБНХУ-ын бодлого бараг ХХ зууны турш үргэлжлэн залгамжилсан тухай дүгнэлтэд хүрчээ. Түүгээр ч барахгүй энэ дүгнэлтээ зохиогч улам тодруулан зохиолын төгсгөлийн бүлэгт том үсгээр товойлгон нотолсон байна. ХХ зууны турш Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудлаархи

Орос, Хятадын бодлогын талаар санаагаа Б.Лхамсүрэн дүгнэж:” Монголын тусгаар тогтнол нь түүнийг үгүйсгэн цуцлах гэсэн өмнөд хөршийн эрмэлзэл, ил далд явууллагатай тулгарсныг түүх гэрчилнэ” /114-р тал/ гэж бичжээ. Харин Орос улсын байр суурь өөр байсан гэж Б.Лхамсүрэн үнэлэхдээ. “Хаант Орос улс ба Зөвлөлт Орос улсын аль алин нь Монголыг эзлэн авах буюу өөртөө нийлүүлэх хэмээгээдүй. Ар Монголыг хязгаарлагдмал эрхтэй бамбай улс байлгах гэсэн Оросын хаант засгийн бодлогыг Зөвлөлт засаг өвлөн аваад тус орныг зөвлөлт маягаар шинэчлэх, бас ч түүнтэй хил залгаа нутаг дэвсгэр рүү хувьсгал дэлгэрүүлэх түшиг газар болгох сонирхолтой байв”/мөн тэнд/ гэжээ.

Энд иш татсанаас үзвэл зохиогч нэгд, Оросын бодлого Октябрийн хувьсгалын өмнө хойно өөрчлөгдөөгүй гэсэн санааг тууштай баримталж хоерт, Монголын талаархи ЗХУ-ын байр суурьд бүхэлд нь сөрөг үнэлэлт өгчээ. Тэгэхдээ зохиогч зарим талаар тууштай биш байдал гаргасан нь дээр иш татсан өгүүлбэртэй залган” дайны аюул өсч дэлхийг хамарсан, тус орны гадаад байдал нэн тааламжгүй байсан нөхцөлд ЗХУ-ыг түшиглэсэн нь 70 жилийн турш Монгол улс оршин тогтносоны шийдвэрлэх хүчин зүйл мөн байв- / мөн тэнд/ гэж бичсэнээс харагдах бөгөөд өөрөөр хэлбэл, ХХ дугаар зууны дийлэнхи хэсгийн турш Монгол улс тусгаар тогтнон оршиход ЗХУ-ын шийдвэрлэх үүрэгтэй байсныг өөрөө хүлээн зөвшөөрсөн байна. ХХ зууны Монголын түүхэнд ЗХУ-ын эзлэх байр суурь, гүйцэтгэсэн үүрэгт ийнхүү утга зөрүү, зөрчилтэй үнэлэлт өх Явдал зөвхөн Б.Лхамсүрэн шиг биеэр мэдэх түүхчинд төдийгүй, түүхэн үнэнийг тогтоохыг эрмэлзэгч монголын бусад зарим эрдэмтэдэд ч байдаг юм. Тийм ойлголтод нэгдүгээрт, тухайн үед ноёрхож байсан үзэл суртал базэвлөлтийн монгол судлалын уламжлалд хөтлөгдсөн урьдын өрөөсгөл үнэлэлтээ хянан үзэх гэсэн зохиогчдын хүсэл , хоёрдугаарт, түүхийн янз бүрийн шатан дахь Зөвлөлт Орос ба ЗСБНХУ-ын гадаад бодлогын онол практик нь өөрөө утга зөрүү, олон даврагатай, зөрчилтэй байсан явдал, гуравдугаарт, Монгол дахь түүхийн шинжлэх ухааны өнөөгийн байдал тусгагдсан байна.

Бид Монголын хувьд явуулсан зөвлөлтийн бодлогыг тухайлбал 1924 оны 5-р сарын 31-ний зөвлөлт-Хятадын хэлэлцээрийн жишээн дээр хаант Оросын бодлоготой зарим талаар зэрэгцүүлэх боломжтой, тэгэх нь зүйтэйг зарчимын хувьд үл үгүйсгэх боловч Октябрийн хувьсгалаас урагш,

хойши энэ бодлого өөрчлөгдөөгүй гэж адилтгасан Б.Лхамсүрэнгийн сэдлэгийг нэн маргаантай гэж үзэж байна. Үүнд 1921-1991 онд Монголын талаар зөвлөлтийн бодлого Хэдийгээр тууштай биш, зөрчилтэй байсан авч чухамдаа Зөвлөлт Орос улсын засгийн газар монголын ард түмний Хятадаас тусгаарлан үндэсний биеэ даасан улс байгуулах хүртэл өөртөө засах эрхийг түүхэнд эн тэргүүнээ 1919 онд Зөвшөөрсөн, барон Унгерн тэргүүтэй цагаантны цэргийг бутцохиход болон монголын ард түмний үндэсний тусгаар тогтнол, төр улсаа сэргээн тогтоох нэн чухал нөхцөл болсон 1921 оны ардын хувьсгал ялахад бүх талын, түүний дотор цэрэг зэвсгийн тусламж үзүүлсэн, монголын ардын засгийг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрснийг сануулахад хангалттай. БНМАУ ЗХУ-ын бүх талын тусламжийн ачаар 1939 онд империалист Японы түрэмгий өнгөлзлөгөөс эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалж, хамгийн гол нь төрийнхөө тусгаар тогтносон байдлыг зөвхөн Хятадаар 1946 онд төдийгүй, олон улсын хамтын нийгэмлэгээр зөвшөөрүүлж чадсан билээ.

Учир иймд, Монголын олон улсын эрх зүйн байдлын талаархи Зөвлөлт Орос улс ба ЗСБНХУ-ын бодлого, тунхагласан зарчим, лоозунтайгаа тэр бүр үнэхээр нийцэхгүй, тууштай биш байж хаант Орос улсын бодлогыг зарим талаар санагдуулж байсныг түүхийн баримт гэрчлэх боловч Монголын талаархи Орос улсын 1917 оны 10-р сараас урагш, хойши бодлогыг бүрэн адилтгах нь бидний бодлоор түүхийн ба арга зүйн хувьд буруу болох бизээ. Энэ чухал асуудлыг орос, Монголын түүхчид цаашид нэмэн судлаж саналаа өргөн солилцууштай гэж бид үзэж байна.

Зохиогч Монголын асуудлаар Хятадын баримталсан байр суурьт холбогдох сэдвийг зохих ёсоор хөндөхийн хамт Зөвлөлт-Монголын харилцааг Монголын гадаад улс төрийн орчны үлэмж чухал хүчин зүйл гэж үзэн тэргүүн зэргийн анхаарал тавьжээ. Жишээлбэл 20-оод оны дунд ба сүүлч үеийн үйл явдлыг Б.Лхамсүрэн шинжлэхдээ 1929 оны 6-р сард гарын үсэг зурсан ЗСБНХУ ба БНМАУ-ын хоороондын харилцааны үндсэн зарчмын тухай нууц хэлэлцээрийн роль, ач холбогдлыг нааштай үнэлжээ/ 52-р тал/. Үүний хамт энэ жилүүдэд “ЗХУ ын удирдлагын зүгээс Монголд улс төрийн талаар өөрийн бодлогыг тулгаж дотоод хэрэгт оролцох явдал нэн ялангуяа Коминтерний шугамаар үргэлжилсээр байлаа. Энэ нь 1920-оод оны сүүлчээр МАХН, засгийн удирдлагын дотор барууны хэлбэртэй тэнцэх хуйвалдааныг зохион улмаар тус нам,

засгийн бодлого, үйл ажиллагаанд “зүүний” үлэмж уршиг бүхий ноцтой алдаа завхрал гарахад хүргэсэн” /57-р тал/ гэж тэмдэглэжээ.

БНТува Ард улс оршин тогтнож байх үеийн монгол туваагийн харилцааг туслах журмаар болон Зөвлөлт-Монголын харилцаа, тухайлбал 1920-1940-өөд онд Хилийн асуудлыг зохицуулсан түүхтэй уялдуулан Монгол, Туваагийн харилцаанд Б.Лхамсүрэн ихээхэн анхаарал тавьжээ.

Зохиогч, 30-аад оны үед БНМАУ-ын эргэн тойронд бий болсон олон улсын улс төрийн байдал, түүний дотор Хятад, Монгол болон бусад оронд Японы түрэмгийлэх төлөвлөгөө, Манж-Гогийн тоглоомын улс байгуулагдсан явдал, 30-аад оны дундуур БНМАУ-ын эсрэг японы дайнчдын өдүүлсэн зэвсэгт өдөөн хатгалгаа, 1936 онд байгуулсан зөвлөлт-Монголын харилцан туслалцах тухай протокол, Халх голын дайн зэргийг нэлээд тодорхой бөгөөд нотолгоотой тусгажээ. Б.Лхамсүрэн Халх голын тулалдаан, дэлхийн хоёрдугаар дайн, милитарист Японыг бут цохих үеийн монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны ач холбогдлыг урьдын адил өндөр үнэлж дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн шат болон түүний дараахан жилүүдэд Монголын олон улсын эрх зүйн статусыг шийдвэрлэсэн түүхэнд онцгой анхаарал тавьжээ.

Б.Лхамсүрэнгийн дүгнэснээр “Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл бол БНМАУ-д гадаад орчноос хандах хандлагад чанарын өөрчлөлт гарч эхэлсэн зааг үе байв. Өөрийн нутаг дэвсгэр, өөрийн хүн амтай, засаглалын бүхийл талыг хэрэгжүүлэх өөрийн засгийн газартай шинэ Монгол улс үүссэн цагаасаа олон улсын эрхийн этгээд мөн билээ. Харин түүний бүрэн эрхийг гадаад улсууд хүлээн зөвшөөрөх явдал нийгмийн байгууламж, үндэсний сонирхол, улс төрийн бодлогын ялгаварын улмаас хязгаарлагдмал байсантай холбогдон олон улсын тавцан дээр тус улс эрхээ эдлэх боломж нэн хомс явж иржээ” /81-82-р тал/.

Бүрэн эрхэт Монгол улсыг бүрэн дүүрэн зөвшөөрөх явдал 25 жилийн турш сунжирсны гол шалтгааныг зохиогч таван зүйлээр томъёолсон нь: 1. ЗХУ-ын зүгээс Монголыг дефакто зөвшөөрснөөс деюре зөвшөөрөхөд шилжсэн, 2. Чанкайшийн гоминданы засгийн газраас Гадаад Монголын /БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөх асуудал, 3. БНМАУ-ын тусгаар тогтнолыг АНУ, Их Британи хүлээн зөвшөөрсөн, 4. Ялтын бага хурлын шийдвэр,

5. Монголын үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөнд ар, өвөр монголчуудын эв санааны нэгдэл эдгээр болно/ 82-84-р тал. Энд дурдсан иж бүрэн шалтгааныг бид зарчмын хувьд маргахгүй хэдий боловч тэдгээрийн дотроос Монголын талаархи Зөвлөлтийн бодлогыг зохиогч яагаад эхний байранд тавив гэдэг асуудал бидэнд төрж байна. Зөвлөлт Орос улс бүр 1921 оны 11-р сарын 5-нд Монгол Ард улсыг хүлээн зөвшөөрч цаашид ЗСБНХУ 1924 оны 5-р сарын 31-нд Зөвлөлт-Хятадын хэлэлцээрт гарын үсэг зурсан боловч Монголын тусгаар тогтнолын үзэл санааг ямагт хүлээн зөвшөөрч хамгаалсаар ирсэн нь мэдээж билээ. Бидний бодлогоор, гол шалтгаан нь 1946 он хүртэл Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөхийг шууд татгалзсаар байсан Хятадын байр сууринд оршино.

Монголын нам, төрийн зарим өндөр тушаалтны зүгээс БНМАУ-ыг ЗСБНХУ-д нийлүүлэх тухай асуудал тавьж шийдвэрлүүлэх оролдлого удаа дараа хийж байсан ба тэрхүү оролдлогод Зөвлөлтийн удирдагчид хэрхэн хандаж байсныг дурсаагүй, зохих тайлбар хийгээгүй дутагдал анхаарал татаж байна.

“Социалист системийн ба түүний задралын үе дэх Монголын гадаад улс төрийн харилцаа” хэмээх зохиолын сүүлчийн бүлэг судлаачдад болон жирийн уншигчдад ихээхэн сонирхолтой юм. Түүнд, дэлхийн 2-р дайны дараахь жилүүдэд олон улсын дундахь Монголын байдалд гарсан үндсэн өөрчлөлтүүдийн ерөнхий товч тоймыг гаргахын зэрэгцээгээр 90-ээд оны эхнээс Монголын гадаад дотоод бодлого үндсээр өөрчлөгдсөнийг товч тодорхойлжээ. “Газар зүйн байрлал болон олон жилийн харилцааны түүхэн уламжлалтай уялдан, ЗХУ-ыг залгамжилсан Холбоот Орос улс ба БНХАУ-тай харилцах явдал Монголын гадаад бодлогод тэргүүн зэргийн ач холбогдолтой хэвээр байна” /116-117-р тал/ гэж зохиогч тэмдэглээд хоёр хөршийн аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, тэдэнтэй найрсаг бөгөөд тэнцвэртэй харилцах чиг шугамыг өнөөгийн Монгол улс баримталж байна гэжээ. Тус улсын аюулгүй байдлын үзэл баримтлалд баталгаажуулсан “тэнцвэртэй харилцаа” гэж адил барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого, мөн түүнчлэн хөрш хоёр орны маргаанд үл оролцож төвийг сахих бодлогыг ойлгож байна /117-р тал/. Ийм бодлого Орос, Хятад хоёрын ч ашиг

сонирхолд нийцнэ гэсэн зохиогчийн санааг өнөөгийн нөхцөлд зөвшөөрөхгүй байх аргагүй.

Төгсгөлд нь дүгнэн тэмдэглэхэд, бидний шүүмж бичиж байгаа Б. Лхамсүрэнгийн бүтээл бол сүүлчийн зуун жилийн дотор их бага, хөгжилтэй буурай орнуудын сонирхол зөрчилдөөн мөргөлдсөн нөхцөлд үндэсний тусгаар тогтнол, төр улсынхаа төлөө монголын ард түмний тэмцсэн түүхийн нарийн төвөгтэй иж бүрэн асуудлыг олон жил шинжилснийхээ үр дүнг нэгтгэсэн эрдэм шинжилгээний үнэт бүтээл болж, төв ба дорнод азийн дэд бүс нутаг дахь олон улсын харилцааны түүхийг монголын үндэсний сонирхлын үүднээс Орос, Хятад, АНУ, Япон зэрэг улсын гадаад бодлоготой уялдуулан нэхэн үзэх гэсэн анхны, бүхэлдээ урагштай оролдлогын нэг болжээ гэж үзүүштэй байна.

/Оросын ШУА-ийн “Восток” сэтгүүлийн 1997 оны 2 дугаараас орчуулав/.